*ОРОН НУТГИЙН АЖИЛТНУУДАД ЗОРИУЛАВ.*

# ЭДИЙН ЗАСГИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ОРОН НУТГИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНД АШИГЛАХ НЬ

**Г.БАТЗОРИГ** /СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН/

2015.04.01

# АГУУЛГА

1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙГ ТОДОРХОЙЛОХ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ
2. СТАТИСТИКИЙН ТОВЧОО НОМОНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР
3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ИНДЕКС, ХОЛБОГДОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

# 1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙГ ТОДОРХОЙЛОХ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ

# 1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙГ ТОДОРХОЙЛОХ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ

## Зорилго:

- Орон нутгийн түвшинд бодлого боловсруулах, төлөвлөх
- Төсөвлөлтийн эрх зүйн орчныг шинэчлэх
- Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага, хяналт шинжилгээний тогтолцоог үндэсний болон орон нутгийн түвшинд сайжруулах
- Бодлого боловсруулалтыг илүү уялдаатай, зохицуулалттай болгох
- Орон нутгийг жигд хөгжүүлэх
- Төсвийн хөрөнгө оруулалтыг аймаг, нийслэлийн хөгжлийн бодит түвшинд тулгуурлан оновчтой хуваарилах, үр ашигтай зарцуулахад ашиглах

# 1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙГ ТОДОРХОЙЛОХ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ

## Ач холбогдол:

Улсын хэмжээнд орон нутгийн хөгжлийн түвшинг илэрхийлэх үзүүлэлтүүдийг тодорхойлж, үзүүлэлтийн системийг боловсронгуй болгон хөгжүүлснээр:

- аймгуудын хөгжлийн түвшинг тодорхойлж, эрэмбэлэх
- орон нутгийг хөгжүүлэх цогц бодлогыг боловсруулах
- төв болон орон нутгийн хөгжил, салбарын хөгжлийн төлөвлөлтийг бүс нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулах
- эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах
- байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалах

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧОО НОМОНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

ӨМНӨХ ҮГ

АЙМГИЙН ТАНИЛЦУУЛГА

ХҮН АМ, НИЙГЭМ

1. Хүн ам
2. Нийгмийн зарим үзүүлэлтүүд
3. Боловсрол, соёл
4. Эрүүл мэнд,
5. Нийгмийн даатгал
6. Гэмт хэрэг, шүүх

ЭДИЙН ЗАСАГ

7. Дотоодын нийт бүтээгдэхүүн
8. Хөрөнгө оруулалт
9. Хэрэглээний үнэ
10. Банк, санхүү, даатгал
11. Төрийн санхүү
12. Хөдөө аж ахуй
    - Мал аж ахуй
    - Газар тариалан
13. Тээвэр, харилцаа холбоо
14. Барилга, нийтийн аж ахуй
15. Байгаль орчин
16. Газрын нэгдмэл сан



# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

## Хамрах хүрээ

| Бүлэг | Аймгаар | Сумдаар | Багаар |
|---|---|---|---|
| 1. ДНБ | + | | |
| 2. Хөрөнгө оруулалт | + | | |
| 3. Хэрэглээний үнэ | + | | |
| 4. Банк, санхүү | + | + | |
| 5. Төрийн санхүү | + | | |
| 6. ХАА | + | + | |
| МАА | + | + | + |
| Газар тариалан | + | + | |
| 7. Тээвэр, харилцаа холбоо | + | | |
| 8. Барилга орон сууц, НАА | + | + | |
| 9. Байгаль орчин | + | + | |
| 10. Газрын нэгдмэл сан | + | + | |

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

## Анхан шатны мэдээллийн эх үүсвэр:

| Бүлэг | Мэдээллийн эх үүсвэр |
|---|---|
| 1. ДНБ | Салбаруудын нэмэгдэл өртгийн тооцоо |
| 2. Хөрөнгө оруулалт | Сангийн яамны хөрөнгө оруулалтын мэдээ |
| 3. Хэрэглээний үнэ | Сум, аймаг, дүүрэг нийслэлийн СХ, СГ-ын үнийн мэдээ |
| 4. Банк, санхүү | Монголбанкны арилжааны банкуудын тайлан тэнцлийн мэдээ |
| 5. Төрийн санхүү | Сангийн яамын нэгдсэн төсвийн орлого, зарлагын мэдээ |
| 6. ХАА | Жил бүрийн мал тооллого, хашаа худгийн болон бусад ХАА-н тооллого судалгаа |
| 7. Тээвэр, харилцаа холбоо | Аймаг, нийслэлийн СХ, СГ-ын авто тээвэр, харилцаа холбооны мэдээ |
| 8. Барилга, нийтийн аж ахуй | Аймаг, нийслэлийн СХ, СГ-ын барилга, НАА-н мэдээ болон захиргааны статистик мэдээллүүд |
| 9. Байгаль орчин | Байгаль орчны яамын мэдээ, Цаг уур, орчны шинжилгээний газрын мэдээ, ОБЕГ-ын мэдээ, болон бусад холбогдох захиргааны мэдээ |
| 10. Газрын нэгдмэл сан | Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын тайлан |

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

## 1. Дотоодын нийт бүтээгдэхүүн

МУ-ын нутаг дэвсгэрийн хүрээнд дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн нэг жилийн хугацаанд шинээр бий болгосон нийт нэмэгдэл өртгийн хэмжээ.

Нийт үйлдвэрлэл

ДНБ (нэмэгдэл өртөг + бүтээгдэхүүний татвар - татаас) | Завсрын хэрэглээ

**ДНБ, үйлдвэрлэлийн аргаар**

| Ажиллагчдын цалин | Үйлдвэрлэл-тийн цэвэр татвар | ҮХЭ | Ашиг, холимог орлого(цэвэр) |
|---|---|---|---|

**ДНБ, орлогын аргаар**

| Эцсийн хэрэглээ | Нийт хөрөнгийн хуримтлал | Экспорт - Импорт |
|---|---|---|

**ДНБ, эцсийн ашиглалтын аргаар**

2014: ҮСХ-ын даргын *1/134 тоот тушаалаар “ДНБ, ҮНО тооцох аргачлал”*

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

## ДНБ-ий үйлдвэрлэлийн арга:

- ДНБ, салбараар, жилээр, оны болон зэрэгцүүлэх үнээр
- ДНБ, салбараар, улирлаар, оны болон зэрэгцүүлэх үнээр
- ДНБ, аймаг, бүсийн тооцоо, жилээр, оны үнээр
- ДНБ, аймаг, бүсийн тооцоо, жилээр, салбарын бүтцээр
- Нэг хүнд ногдох ДНБ, бүс, аймаг, нийслэлээр, оны үнээр
- Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ, ам.доллараар (Дэлхийн банкны Атласын аргаар)
- Хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь, салбараар
- Бүтээмж
- Төсвийн орлого, зардал, тэнцэлд ДНБ-ий эзлэх хувь

## ДНБ-ий эцсийн ашиглалтын арга:

- ДНБ, жилээр, оны болон 2010 оны зэрэгцүүлэх үнээр
- ДНБ, улирлаар, оны болон 2010 оны зэрэгцүүлэх үнээр

## ДНБ-ий орлогын арга:

- ДНБ, жилээр, оны үнээр

## 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

**Ач холбогдол:**

- ***Бодит ДНБ-ий өсөлт нь*** эдийн засгийн нийт чадавхийг илтгэнэ.
- ***Нэг хүнд оногдох ДНБ-ий өсөлт нь*** улс орны иргэдийн амьжиргааны түвшинг илтгэнэ.

**ДНБ-ийг аймаг, нийслэлийн түвшинд тооцсоноор:**

- аймаг, нийслэл, бүсийн хэмжээнд гарсан эдийн засгийн өсөлт, түүний бүтцийн байдалд дүн шинжилгээ хийх
- улс орны эдийн засагт аймаг, нийслэл, бүсийн эзэлж буй байр суурийг харуулах
- аймгийн нэг хүнд ногдох ДНБ-ийг тооцсоноор тухайн аймгийн иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлох боломж бүрдэнэ.

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

## ДНБ-ий бүтэц, дэд салбараар, 2013 оны байдлаар, бүс, нийслэлээр



# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

**Нэг хүнд ногдох ДНБ, 2013 оны байдлаар, оны үнээр, аймаг, нийслэлээр, мян.төг**



## 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

### 2. Хөрөнгө оруулалт

- Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хуримтлалыг шинээр бий болгох, түүний техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэн өргөтгөх, сайжруулахад зориулж, тайлант жилд зарцуулсан хөрөнгө, хайгуулын ажлын зардал

- Хөрөнгө оруулалтыг технологийн бүтцээр
  - барилга угсралтын ажил,
  - машин, тоног төхөөрөмж,
  - геологи хайгуулын зардал болон бусад зардал (зураг төсөв, бусад биет бус хөрөнгө) ангилна.

## 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

- ***Барилга угсралтын ажилд*** *барилга байшин барих болон зам, гүүр, далан зэрэг инженерийн байгууламжийг барих хэлбэрээр үндсэн хөрөнгийг бий болгох, шинэчлэх, засварлах, өргөтгөхөд чиглэсэн үйл ажиллагааг хамруулна.*

- ***Машин, тоног төхөөрөмжид*** *бүх төрлийн тээврийн хэрэгсэл, механик тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг, эд ангийг хамруулна.*

- ***Бусад зардалд*** *зураг төсөв, програм хангамж, мэдээллийн сан, биет бус хөрөнгийн зардлыг хамруулна.*

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

- Хөрөнгө оруулалт нь гадаад, дотоод санхүүжилтийн эх үүсвэрээс бүрэлдэнэ.

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, сая төгрөг

| Үзүүлэлт | 2011 | 2012 | 2013 | 2013/2012 % |
|---|---|---|---|---|
| Улсын төсвийн хөрөнгө оруулалт | 31574.8 | 13333.9 | 16483.2 | 123.6 |
| Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт | 980.5 | 2039.9 | 680.6 | 33.4 |
| -орон сууцны бус барилга, байгууламж | 432.3 | 599.9 | 252.1 | 42.0 |
| -машин, тоног төхөөрөмж | 400.3 | 424.8 | 304.7 | 71.7 |
| -мал, ургамал | - | - | - | - |

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

## Ач холбогдол:

- Хөрөнгө оруулалтын статистик нь улс орны хөгжлийн төлөв байдал, бодлого боловсруулахад шаардлагатай суурь чухал мэдээлэл болдог.
- **Хөрөнгө оруулалтын үр ашиг** (нэг төгрөгийн хөрөнгө оруулалтад ногдох ДНБ) – Хэрэв энэ үзүүлэлт нэмэгдэж байвал хөрөнгө оруулалтын үр ашиг нэмэгдэж байгааг харуулна. Ялангуяа тэргүүлэх салбараар авч үзэх нь илүү ач холбогдолтой юм.
- **Хөрөнгө оруулалтын бүтэц** нь тухайн улс орны хөгжлийн чиг хандлагыг тодорхойлдог.

## 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

### 3. Хэрэглээний үнэ

**Хэрэглээний үнийн индекс (ХҮИ)** - Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг илэрхийлэх үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлт.

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

**ÕÝÐÝÃËÝÝÍÈÉ ҮÍÈÉÍ ÈÍÄÅÊÑ**

ХҮИ-ийн тооцоонд ***хэрэглээний сагс, хэрэглээний жин*** гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглана.

**Õýðýãëýýíèé ñàãñ**

¯íèéã íü ñóäëàõààð ñîíãîæ àâñàí, òºëººëºõ Чàäâàð á¿õèé áàðàà, ¿éëЧèëãýýíèé  íýð òºðëèéí áàãö

**Õýðýãëýýíèé æèí**

ªðõèéí íèéò çàðäàëä òóõàéí áàðàà, ¿éëЧèëãýýíèé ýçëýõ õóâü (ªНЭÇÑ-ны дүн)

Аймаг:
- Сар бүр **/214 нэр төрөл,** 21 аймгийн төв, тус бүр 50 гаруй цэг**/**
- 7 хоног бүр гол нэрийн 12 бараа (7 цэг)

Нийслэл:
- Сар бүр **/329 нэр төрөл,** төвийн 6 дүүргийн 400 гаруй цэг**/**
- 7 хоног бүр гол нэрийн 41 бараа (20 цэг)

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

**Ач холбогдол:**

- ✓ Инфляцийн түвшинг тодорхойлох,
- ✓ Санхүү, мөнгө, зээлийн бодлогыг боловсруулах мэдээллийн эх үүсвэр,
- ✓ Хүн амын цалин, тэтгэвэр, тэтгэмж, бусад орлогын хэмжээг индексжүүлэх,
- ✓ Дотоодын нийт бүтээгдэхүүнийг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэх дефлятор болгох.

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

**Инфляци** Говь-Алтай аймагт 2013 оны байдлаар инфляци 9.1 хувь байгаа нь улсын түвшнээс 3.4 пунктээр доогуур байв. Инфляцийн 9.1 хувийн өсөлтийн 4.5 нэгж буюу (49.9 хувь) нь хүнсний барааны бүлгийн, 2.3 нэгж буюу (25.1 хувь) нь хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

**ИНФЛЯЦИЙН 2013 ОНЫ ӨСӨЛТӨД ҮЗҮҮЛСЭН БҮЛГҮҮДИЙН НӨЛӨӨЛӨЛ**

| Бараа, үйлчилгээний бүлэг | Улс | | Говь-Алтай аймаг | |
|---|---|---|---|---|
| | Пункт | Хувь | Пункт | Хувь |
| Ерөнхий индекс | 12.5 | 100.0 | 9.1 | 100.0 |
| 01.Хүнсний бараа, согтууруулах бус ундаа | 4.0 | 32.0 | 4.5 | 49.9 |
| 02.Согтууруулах ундаа, тамхи | 0.5 | 4.3 | 2.2 | 23.8 |
| 03.Хувцас, бөс бараа, гутал | 3.0 | 23.8 | 2.3 | 25.1 |
| 04.Орон сууц, ус, цахилгаан, түлш | 1.0 | 7.8 | -0.4 | -3.9 |
| 05.Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа | 0.8 | 6.4 | 0.0 | 0.1 |
| 06.Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ | 0.4 | 3.4 | 0.0 | 0.0 |
| 07.Тээвэр | 0.4 | 2.9 | 0.1 | 1.6 |
| 08.Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ | 0.0 | -0.1 | -0.1 | -0.7 |
| 09.Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ | 0.0 | 0.1 | 0.0 | 0.0 |
| 10.Боловсролын үйлчилгээ | 1.3 | 10.5 | 0.4 | 4.8 |
| 11.Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ | 0.5 | 3.9 | 0.0 | 0.3 |
| 12.Бусад бараа, үйлчилгээ | 0.6 | 5.1 | -0.1 | -1.0 |

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Өргөн хэрэглээний бараа, үйлчилгээндээ төлж буй үнийн түвшингээс харахад Цогт, Баян-Уул, Дэлгэр сум бусад сумдаас илүү өндөр үнэтэй байна.

**ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРИМ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДУНДАЖ ҮНЭ, сумаар**

| Нэр төрөл | Баян-Уул | Дэлгэр | Халиун | Хөхморьт | Цогт | Эрдэнэ |
|---|---|---|---|---|---|---|
| Гурил, I зэрэг, кг | 800 | - | - | - | 950 | - |
| Цагаан будаа, кг | 1910 | 1957 | 1852 | 1871 | 2181 | 2110 |
| Хонины мах, кг | - | - | - | - | - | - |
| Үхрийн мах, кг | - | - | - | - | - | - |
| Шингэн сүү, л | 1133 | 1400 | - | 1238 | - | 1317 |
| Өндөг, ш | 400 | 400 | 414 | 464 | 400 | 457 |
| Төмс, кг | 743 | 624 | 500 | 693 | 857 | 857 |
| Лууван, кг | 1500 | 1429 | 1000 | 1464 | 1500 | 1386 |
| Элсэн чихэр, кг | 1857 | 1886 | 1729 | 1862 | 1800 | 1995 |
| Цахилгаан, кВтц | - | 89 | 80 | 87 | - | 93 |
| Бензин, А-80, л | - | 1750 | 1800 | 1720 | - | 1807 |

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

## АЙМГИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН МЭДЭЭНД ХАМРАГДДАГ СУМД



# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

## 4. Банк, санхүү, даатгалын зах зээл

**Хадгаламж** - Тухайн данс эзэмшигч хүүний орлого олох зорилгоор хугацаатай эсвэл хугацаа заахгүйгээр хадгаламжийн байгууллагад байршуулсан мөнгөн хадгаламж.

**Зээл -** Иргэд, байгууллагад олгосон зээлийн үлдэгдлийг зээлийн чанар буюу хугацааны үзүүлэлтээр хэвийн, хугацаа хэтэрсэн, чанаргүй зээл гэж ангилна. Зээлийн өрийн үлдэгдлийг улсын байгууллага, хувийн хэвшил, иргэд, бусад санхүүгийн бус байгууллага, санхүүгийн бусад байгууллага гэсэн ангиллаар, нийт дүнгээр нь мэдээлнэ.

**Хэвийн зээл** гэж төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.

**Хугацаа хэтэрсэн зээлийг** зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлээр тодорхойлогдоно.

**Чанаргүй зээлийг** хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлээр тооцож гаргана

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

**Хадгаламж, зээл**. Говь-Алтай аймгийн нийт хадгаламж 2013 оны эцэст 38.1 тэрбум төгрөгт хүрч 2010 оноос 2.2 дахин, өмнөх оныхоос 23.4 хувь буюу 7.2 тэрбум төгрөгөөр өслөө.

Улсын хэмжээнд нэг сумын хадгаламжийн дундаж хэмжээ 2918.6 сая төгрөг байгаа бол Говь-Алтай аймгийн сумын дундаж 2117.7 сая төгрөг байна. Тонхил сум нь хамгийн их хадгаламжтай байна.

Улсын хэмжээнд нэг өрхийн хадгаламжийн дундаж 1998.3 мянган төгрөг, Говь-Алтай аймагт 2422.5 мянган төгрөг байгаа нь аймгууд дотор тавдугаар байранд орж байна.

**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, сая төгрөг**

| Үзүүлэлт | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2013/2012 % |
|---|---|---|---|---|---|
| Нийт хадгаламж | 16,982.1 | 23,265.3 | 30,900.0 | 38,117.8 | 123.4 |
| Хугацаатай | 11,178.0 | 14,873.6 | 20,704.3 | 26,412.5 | 127.6 |
| Хугацаагүй | 5,804.2 | 8,391.7 | 10,195.7 | 11,705.3 | 114.8 |
| Иргэдийн хадгаламж | 24,639.4 | 32,869.1 | 41,374.2 | 50,832.3 | 122.9 |
| Зээлийн өрийн үлдэгдэл | 21,334.9 | 35,173.4 | 44,285.9 | 68,576.2 | 154.8 |
| Хадгаламж, зээлийн хоршоодын тоо | 3 | 2 | - | - | - |
| Хүүгийн орлого | 3.6 | 4.3 | - | - | - |
| Хүүгийн зарлага | 0.2 | - | - | - | - |

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

| | | Хамгийн их | Хамгийн бага |
|---|---|---|---|
| 1 | Нийт хадгаламж /аймаг/ | Дархан-Уул | Дундговь |
| 2 | Зээлийн өрийн үлдэгдэл /аймаг/ | Дархан-Уул | Дундговь |
| 3 | Даатгуулсан өрхийн тоо /нийт малчин өрхөд харьцуулсан хувиар/ | Баянхонгор | Хөвсгөл |
| 4 | Даатгуулсан малын тоо /оны эцсийн нийт малд харьцуудсан хувиар/ | Баянхонгор | Хөвсгөл |

**Аймаг орон нутгийн хэмжээнд нэг хүнд ногдох хадгаламжийн үлдэгдлийн хэмжээ, нэг хүнд ногдох зээлийн үлдэгдлийн хэмжээг тооцно.**

## 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Өнөөгийн нөхцөлд индекст суурилсан малын даатгалын хэлбэр Монгол Улсын хувьд тохиромжтой эсэхийг тогтоох зорилгоор “Малын индексжүүлсэн даатгал төсөл”-ийг газар зүйн онцлогийг илэрхийлэхүйц аймгуудыг сонгон туршилтын журмаар хэрэгжүүлсэн. Дараах үзүүлэлтүүд гарна:

- даатгуулсан өрхийн тоо,
- малчин өрхөд эзлэх хувь,
- даатгуулсан малын тоо,
- нийт малын дунд эзлэх хувь,
- даатгалын хураамжийн орлого.

## 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

***Малын индексжүүлсэн даатгал (МИД)*** *- Индекст суурилсан даатгал нь байгалийн давагдашгүй хүчин зүйлээс учрах эрсдэлээс хамгаалах зорилготой, даатгалын нэгж тохиолдолд бус, тодорхой үзүүлэлтүүдэд үндэслэн хохирлын нөхөн төлбөрийг олгодог даатгалын хэлбэр.*

***Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)*** *– ББСХ нь зээл олгох; факторингийн үйлчилгээ, санхүүгийн түрээсийн үйлчилгээ, төлбөрийн баталгаа гаргах үйлчилгээ, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйлчилгээ, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, гадаад валютын арилжаа, итгэлцлийн үйлчилгээ, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээ зэрэг үйл ажиллагаа явуулдаг.*

***Хоршоо*** *гэж эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, хамтын удирдлага, хяналт бүхий, дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар хамтран байгуулсан хуулийн этгээдийг хэлнэ.*

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

**Малын даатгал**. Говь-Алтай аймагт 1332 өрхийн 221.5 мянган толгой мал даатгалд хамрагджээ. Нийт малын 10.0 хувь даатгалд хамрагдаад байгаа нь аймгууд дотор тавдугаарт, нийт мал бүхий өрхийн 14.2 хувь даатгалд хамрагдсан нь аймгууд дотор тавдугаарт орох үзүүлэлт юм. Нийт сумдын дотор Чандмань сум хамгийн их буюу оны эхний малын 36.1 хувь, Алтай сум хамгийн бага буюу 0.5 хувийг даатгуулсан байна.

**МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛД ХАМРАГДСАН МАЛ БҮХИЙ ӨРХ, ДААТГУУЛСАН МАЛЫН ТОО**

| Үзүүлэлт | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2013/ 2012 % |
|---|---|---|---|---|---|
| Даатгуулсан өрхийн тоо | 945 | 1,116 | 1,321 | 1,332 | 100.8 |
| Мал бүхий өрхөд эзлэх хувь | 9.9 | 12.1 | 14.3 | 14.2 | 99.3 |
| Даатгуулсан малын тоо, мян.тол | 112.1 | 127.7 | 167.3 | 221.5 | 132.4 |
| Нийт малын дүнд эзлэх хувь | 8.5 | 7.9 | 8.8 | 10.0 | 113.6 |
| Даатгалын хураамжийн орлого, сая төг | 83.2 | 91.3 | 140.0 | 139.4 | 99.6 |

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

## 5. Төрийн санхүү




***Улсын төсөв** - Улсын Их Хурлаас баталсан, Засгийн газар бүрдүүлэн, зарцуулах төсөв*

***Орон нутгийн төсөв -** Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрдүүлэн, зарцуулах төсөв /аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвөөс бүрдэнэ./*

*Монгол Улсын төсвийн жил тухайн оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхэлж 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болдог.*

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

***Төсвийн орлого** :*

| | |
|---|---|
| Тогтворжуулалтын сан | • Тогтворжуулалтын сан |
| Тэнцвэржүүлсэн орлого | • Урсгал орлого 1. Татварын<br>2. Татварын бус<br>• Хөрөнгийн орлого<br>• Тусламжийн орлого |

*Татварын орлогод орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, хураамж, өмчийн татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, гадаад худалдааны татварын орлого болон бусад татвар орно.*

*Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, хүү, торгуулийн орлого, түрээсийн орлого, төсөвт газрын өөрийн орлого болон бусад орлогоос татварын бус орлогыг бүрдүүлдэг.*

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

***Төсвийн зарлага*** *:*

Урсгал зардал /бараа, үйлчилгээний болон зээлийн үйлчилгээний төлбөр, татаас шилжүүлэг багтана.

Хөрөнгийн зардал

Цэвэр зээл

***Төсвийн тэнцвэржүүлсэн нийт ашиг /алдагдал/ =*** *нийт орлого, тусламжийн дүн - нийт зарлага, цэвэр зээлийн дүн*

*Урсгал тэнцэл = урсгал орлого - урсгал зардал*

Аймаг орон нутгийн хэмжээнд нэг хүнд ногдох төсвийн зарлага болон татварын орлогыг хэмжээг тооцно.

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

**Төсвийн орлого, зарлага**. Аймгийн төсвийн орлого, тусламжийн хэмжээ 2013 оны урьдчилсан гүйцэтгэлээр 49.3 тэрбум төгрөг болжээ. 2013 онд нийт орлого, тусламжийн дунд тусламжийн орлого 43.6 тэрбум төг буюу 88.4 хувь, урсгал орлого 5.7 тэрбум төг буюу 11.6 хувийг эзэлж байна. Аймгийн төсвийн нийт орлого, тусламжийн дүн 2013 онд 2010 оныхоос 9.6 дахин нэмэгдсэн бөгөөд үүний дотор тусламжийн орлого 5.2 дахин нэмэгдсэн байна. Аймгийн төсвийн нийт зарлага 2013 онд 47.1 тэрбум төгрөгт хүрчээ. Нийт зарлагын дунд урсгал зардал 90.0 хувь, хөрөнгийн зардал 10.0 хувийг бүрдүүлж байна.

**АЙМГИЙН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ, тэрбум төгрөг**



# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

## АЙМГИЙН ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО, ЗАРЛАГА, сая төг

| Үзүүлэлт | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2013/2012 % |
|---|---|---|---|---|---|
| Нийт орлого ба тусламжийн дүн | 5150.1 | 8366,1 | 10793.0 | 49322.3 | 958 |
| Урсгал орлого | 4212.1 | 7192.2 | 10444.0 | 5739.0 | 136.2 |
| Татварын орлого | 3832.0 | 6819.2 | 9764.9 | 4859.5 | 126.8 |
| Татварын бус орлого | 380.1 | 373.0 | 679.1 | 879.4 | 231.4 |
| Хөрөнгийн орлого | 105.6 | 104.2 | 93.7 | - | - |
| Тусламжийн орлого | 832.4 | 1069.8 | 255.2 | 43583.4 | 5235 |
| Нийт зарлагын дүн | 4771.2 | 7390.7 | 10959.5 | 47079.0 | 987 |
| Урсгал зардлын дүн | 4300.6 | 5849.8 | 7893.9 | 42408.4 | 986 |
| Хөрөнгийн зардал | 470.6 | 1540.9 | 3065.6 | 4670.7 | 992 |
| Төсвийн тэнцэл | 378.9 | 975.4 | -166.5 | 2243.3 | |

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

## 6. Хөдөө аж ахуй

**Мал аж ахуйн статистик үзүүлэлтүүд:**

- малчин өрх, малчид, тэдгээрийн соёл ахуйн зарим үзүүлэлтүүд
- мал, хээлтэгч мал, бойжуулсан төл
- тэжээвэр амьтад
- хашаа, худаг
- бэлчээрийн даац
- тэжээлийн хүрэлцээ

***Малтай өрхөд*** *малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэйгээр өсгөн үржүүлдэг өрхийг хамруулна.*
***Малчин өрх*** *гэж жилийн 4 улирлын туршид малаа малладаг бөгөөд малын ашиг шим тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа өрхийг хэлнэ.*
***Хээлтэгч малд*** *нас гүйцсэн эм малыг хамруулна.*

## 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

***Төлийн бойжилтын хувийг*** *гаргахдаа бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.*

***100 эхээс бойжуулсан төлийг*** *бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.*

***Зүй бусаад хорогдсон малын*** *тоонд халдвартай, халдваргүй өвчин, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг гэнэтийн аюул болон араатан, жигүүртэнд идүүлэх, хулгай, хавцалд унах зэрэг хариулга, маллагаатай холбоотой шалтгаанаар хорогдсон малыг хамруулна.*

***Хүнсэнд хэрэглэсэн малын*** *тоог тооцохдоо оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасна*

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

**Ач холбогдол:**

- ХАА-н салбарын бодлого боловсруулах, дүн шинжилгээ хийхэд ашиглах мэдээллийн гол эх үүсвэр болдог (бэлчээрийн ашиглалт, хамгаалалт болон усан хангамжийг сайжруулах, малыг эрсдлээс хамгаалах, тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх, мал, түүний гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх зэрэг).
- Мал тооллогын үр дүн буюу “Малын А данс”-ны мэдээлэлд тулгуурлан малчид зээл авдаг.
- Малын индексжүүлсэн даатгалд хамрагдсан малчдад нөхөн олговор олгох мэдээллийн эх үүсвэр болдог.

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

## МАЛ АЖ АХУЙ

### Малчин өрх, малчид, тэдгээрийн соёл ахуйн үзүүлэлтүүд

**Малчин өрх, малчид**. 2014 онд аймгийн хэмжээгээр 9.4 мянган мал бүхий өрх байгаагийн 68.1 хувь буюу 6.4 мянган малчин өрх байгаа нь өмнөх оныхоос 101 өрхөөр цөөрчээ. 12.9 мянган малчдын 35.4 хувь нь 35 хүртлэх насны залуучууд байна. 1990 оныхтой зэрэгцүүлбэл малчин өрхийн тоо 1.6 дахин, малчдын тоо 1.5 дахин нэмэгдсэн байна. 1990 онд нийт малчдын 55.2 хувийг 35 хүртлэх насны залуучууд эзэлж байжээ.

**МАЛЧИН ӨРХ, МАЛЧДЫН ТОО**
**А. Аймгийн дүн, мянга**

| | 1990 | 2000 | 2010 | 2012 | 2013 | 2014 | 2014/2013 % |
|---|---|---|---|---|---|---|---|
| Мал бүхий өрх | 10.2 | 12.6 | 9.5 | 9.3 | 9.4 | 9.4 | 100.0 |
| Малчин өрх | 3.9 | 9.6 | 7.2 | 6.6 | 6.5 | 6.4 | 98.4 |
| Малчдын тоо | 8.4 | 22.3 | 14.8 | 13.3 | 13.1 | 12.9 | 98.5 |
| Үүнээс: 16-34 насны залуучууд | 4.7 | 12.0 | 6.4 | 5.2 | 4.9 | 4.6 | 93.8 |
| Эзлэх хувь | 55.2 | 58.1 | 43.1 | 39.0 | 37.3 | 35.4 | 94.9 |

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

## НИЙТ МАЛД СУМДЫН ЭЗЛЭХ ХУВЬ, 2014 оны байдлаар




**2014 оны байдлаар хамгийн олон малтай сум бол Дэлгэр (аймгийн дүнд эзлэх хувь-8.3%), Цогт (8%) байна. Хамгийн цөөн малтай сум бол Алтай (2.9%), Тайшир (3.3%) байна**

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

## ХАМГИЙН ОЛОН МАЛТАЙ СУМ



# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

**Малын тоо, 2014 оны жилийн эцэст, аймаг, нийслэлээр, мян.толгой**




**Малын тоо, төрлөөр, мян.толгой**

| | 2012 | 2013 | 2014 |
|---|---|---|---|
| Бүгд | **1911.0** | **2223.2** | **2578.1** |
| Адуу | 28.2 | 30.4 | 32.8 |
| Үхэр | 55.0 | 65.3 | 76.7 |
| Тэмээ | 29.5 | 39.4 | 49.4 |
| Хонь | 578.1 | 679.0 | 798.2 |
| Ямаа | 1220.2 | 1409.1 | 1621.0 |







## 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

***Газар тариалан***- *Газар тариалан эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс тариалсан талбай, ургацын мэдээг баг, хороод авч сум/дүүрэгт нэгтгэн, аймаг/нийслэлийн статистикийн хэлтэс/газарт хүргүүлж, улмаар ҮСХ-нд нэгтгэн боловсруулж байна.*

*Манай улсад гол төлөв үр тариа, төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн ургамал зэргийг тарьж ургуулдаг бөгөөд тэдгээрийн тариалсан талбай, хураасан, нэг га талбай тутмаас хураан авсан ургацын хэмжээг улс, орон нутгийн түвшинд тодорхойлно.*

***Хөдөө аж ахуйн газарт*** *бэлчээр, хадлан, тариалан, атаршсан газар, хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулсан бусад газрыг хатруулна (Газрын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалт). Тариалангийн талбайнд хөдөө аж ахуйн ургамал тариалсан талбайг оруулах бөгөөд тухайн жилд үр суулгасан газрын нийт хэмжээгээр тодорхойлно.*

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

***Хураасан нийт ургацыг*** *тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг таримал хэмжээгээр тодорхойлно.*

***Га-гийн ургац*** *нь талбайн нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ юм. Га-гийн ургацыг тодорхойлохдоо нэг төрлийн ургамал тариалсан талбайгаас хураан авсан нийт ургацыг тариалсан талбайн хэмжээнд нь харьцуулна.*

## 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

**Тариалсан талбай**. 2014 онд үр тариа 490.7 га, төмс 109.2 га, хүнсний ногоо 71.9 га, тэжээлийн ургамал 415.3 га-д тариалалт хийв. Өмнөх оныхоос үр тарианаас бусад таримлын бүх төрөл дээр тариалсан талбайн хэмжээ 46.1-23.6 хувиар буурчээ. 1990 оны түвшинтэй зэрэгцүүлбэл аймгийн хэмжээгээр бүх төрөл дээр тариалалт 2.8-6.5 дахин доогуур байна.

**ТАРИАЛСАН ТАЛБАЙ, га**

| | 1990 | 2000 | 2010 | 2012 | 2013 | 2014 | 2014/2013 % |
|---|---|---|---|---|---|---|---|
| Үр тариа | 714.0 | 553.0 | 594.4 | 752.0 | 251.6 | 490.7 | 195.0 |
| Төмс | 164.2 | 155.2 | 200.0 | 280.2 | 174.3 | 109.2 | 62.7 |
| Хүнсний ногоо | 79.5 | 162.2 | 109.7 | 205.7 | 123.1 | 71.9 | 58.4 |
| Тэжээлийн ургамал | 3518.3 | 184.8 | 532.0 | 756.1 | 543.7 | 415.3 | 76.4 |

## 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

**Хураасан ургац**. 2014 онд 475.4 тонн үр тариа, 510.2 тонн төмс, 336.7 тонн хүнсний ногоо, 1048.9 тонн тэжээлийн ургамал хурааж, 4.7 мян.т өвс хадлан бэлтгэв. Өмнөх оныхоос үр тариа 43.0, бэлтгэсэн хадлангийн хэмжээ 2.2 хувиар нэмэгдэж, төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн ургамал 280.1-500.5 тонноор буурсан байна.

1990 оны түвшинтэй зэрэгцүүлбэл аймгийн хэмжээгээр хураасан үр тарианы ургац 1.9 дахин, малын тэжээлийн ургамал 9.9 дахин доогуур байна.

**ХУРААСАН УРГАЦ, тонн**

| | 1990 | 2000 | 2010 | 2012 | 2013 | 2014 | 2013/2012 % |
|---|---|---|---|---|---|---|---|
| Үр тариа | 881.7 | 602.0 | 838.9 | 1169.6 | 332.4 | 475.4 | 143.0 |
| Төмс | 1150.3 | 1217.7 | 1269.6 | 1930.2 | 1010.7 | 510.2 | 50.5 |
| Хүнсний ногоо | 709.2 | 1349.6 | 711.8 | 1348.3 | 616.8 | 336.7 | 54.6 |
| Тэжээлийн ургамал | 10377.5 | 452.0 | 1528.1 | 1832.5 | 1213.7 | 1048.9 | 86.4 |
| Бэлтгэсэн өвс, мян.тонн | 9.0 | 2.0 | 5.3 | 4.2 | 4.6 | 4.7 | 102.2 |

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

## 7. Авто тээвэр, харилцаа холбоо

**Тээсэн ачаа -** тодорхой хугацаанд, тодорхой зайд тээвэрлэсэн нийт ачаа

**Ачаа эргэлт -** тээвэрлэсэн ачааг тээсэн зай/км/-аар үржүүлсэн үржвэрийн нийлбэр

**Тээсэн зорчигч -** тодорхой хугацаанд тодорхой зайд тээвэрлэсэн нийт зорчигчдын тоо

**Зорчигч эргэлт -** зорчигч эргэлтийг зорчсон зорчигчдын тоог аялсан зай/км/-гаар үржүүлсэн үржвэрийн нийлбэр

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

**Шилжүүлсэн т.км -** тээврээр гүйцэтгэсэн олон төрөл, хэлбэрийн ажил, үйлчилгээг тусгай коэффициентуудыг ашиглан нэг нэгжид буюу тонн километрт шилжүүлсэн үзүүлэлт

**Суурин утасны цэг -** нийтийн телефон сүлжээнд хэрэглэгчийн шугамаар телефон станц дээр порт эзлэн зориулалтын төхөөрөмжөөр холбогдсон эцсийн хэрэглэгч

**Гар утас хэрэглэгч -** цахилгаан холбооны нийтийн сүлжээнд хөдөлгөөнт технологийг ашиглан холбогдох боломж бүхий хэрэглэгч

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

**Ач холбогдол:**

- Тээвэр нь орон нутгийн ачаа, зорчигчдыг нэг газраас нөгөөд цаг хугацаанд нь хүргэж үйлчлэхэд чиглэдэг үйлдвэрлэлийн тасралтгүй үйл явц юм.

- Тээврийн салбарын үзүүлэлт нь орон нутгийн хөгжил, техникийн түвшин, үйлдвэрлэх хүчний байршил, зам харилцааны байдлыг илтгэн харуулдагаараа онцлогтой.

- Холбооны салбарын үзүүлэлт нь орон нутгийн мэдээлэл холбооны технологийн хөгжлийг тодорхойлоод зогсохгүй боловсрол болон нийгмийн үйлчилгээний хүртээмж, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг харуулдаг.

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

**Авто тээвэр, харилцаа холбоо**. Аймгийн хэмжээгээр 2013 онд тээвэрлэсэн ачаа өмнөх оныхоос 27.5 хувь, тээвэрлэсэн зорчигчдын тоо 7.4 хувь, тээврийн нийт орлого 22.8 хувиар тус тус буурчээ.

## АВТО ТЭЭВРИЙН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

| Үзүүлэлт | 2011 | 2012 | 2013 | 2013/2012 % |
|---|---|---|---|---|
| Тээвэрлэсэн ачаа, мян.т | 1809.7 | 1303.3 | 944.3 | 72.5 |
| Ачаа эргэлт, сая т.км | 417.7 | 119.3 | 98.6 | 82.6 |
| Зорчигчдын тоо, мян.хүн | 35.9 | 72.0 | 66.7 | 92.6 |
| Зорчигч эргэлт, сая хүн км | 24.2 | 22.1 | 55.9 | 252.9 |
| Шилжүүлсэн сая т.км | 427.4 | 128.1 | 120.9 | 94.4 |
| Тээврийн нийт орлого, сая төгрөг | 4865.5 | 11161.7 | 8616.9 | 77.2 |

## АЙМГИЙН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ҮЗҮҮЛЭЛТ

| Үзүүлэлт | 2011 | 2012 | 2013 | 2013/2012 % |
|---|---|---|---|---|
| Холбооны үйлчилгээний нийт орлого, сая төг | 333.7 | 473.6 | 338.5 | 71.5 |
| Үүнээс хүн амаас орсон орлого, са төг | 39.3 | 125.4 | 162.8 | 129.8 |
| Суурин утасны цэгийн тоо, ширхэг | 932 | 835 | 792 | 94.9 |
| Гар утас хэрэглэгчдийн тоо, мянга | ... | 56.4 | 68.1 | 120.7 |
| Кабелийн телевиз хэрэглэгчдийн тоо | 385 | 396 | 410 | 103.5 |

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

## 8. Барилга, нийтийн аж ахуй

**Барилга угсралт, их засварын ажил** - Монгол Улсын нутаг дэвсгэр дээр баригдаж буй өмчийн бүх төрлийн барилга байгууламж түүний өргөтгөл, шинэчлэл, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулах үйл ажиллагаа.

*Барилга угсралт, их засварын ажлаас дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажлын дүнг ангилж харуулах боломжтой.*

## 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Ач холбогдол:

- *хүн амын ая тухтай, аюулгүй амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн бодлого боловсруулах,*
- *газрын харилцаа, барилга, хот байгуулалт, барилгын материалын үйлдвэрлэл түүнийг дагасан түүхий эдийн олборлолт, төлөвлөлт, судалгаа, шинжилгээнд ашиглах,*
- *орон нутгийн төсөв, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээл, тусламжийг зөв зохистой зарцуулахад ашиглана.*

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

## БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ХЭМЖЭЭ, сумаар, сая төгрөг

| Сумын нэр | 2011 | 2012 | 2013 | 2013/2012 % |
|---|---|---|---|---|
| Есөнбулаг | 2302.0 | 3879.6 | 7110.3 | 183.3 |
| Алтай | 76.8 | 458.4 | - | - |
| Баян-Уул | 129.9 | - | 352.0 | - |
| Бигэр | - | 76.9 | 59.6 | 77.5 |
| Бугат | 89.1 | 223.8 | 110.8 | 49.5 |
| Дарви | 1 20.2 | 568.4 | 114.0 | 20.1 |
| Дэлгэр | 159.6 | 702.2 | 772.8 | 110.1 |
| Жаргалан | 66.8 | 40.0 | 182.9 | 457.3 |
| Тайшир | 30.0 | 323.0 | 49.1 | 15.2 |
| Тонхил | 144.0 | 398.9 | - | - |
| Төгрөг | 401.6 | 25.2 | 105.0 | 416.7 |
| Халиун | - | 27.5 | - | - |
| Хөхморьт | 225.1 | 125.6 | 28.0 | 22.3 |
| Цогт | 140.9 | 176.7 | 77.0 | 43.6 |
| Цээл | 30.0 | 31.6 | 75.0 | 237.3 |
| Чандмань | - | 72.6 | 144.0 | 198.3 |
| Шарга | 7.8 | 83.5 | 49.9 | 59.8 |
| Эрдэнэ | 85.6 | 65.0 | 238.0 | 366.2 |
| АЙМГИЙН ДҮН | 3889.2 | 7278.9 | 9468.4 | 130.1 |
| **Улсын дүнд эзлэх хувь** | **0.59** | **0.79** | **0.54** | - |
| **Бүсийн дүнд эзлэх хувь** | **5.4** | **9.2** | **4.1** | - |

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

## 9. Байгаль орчин, цаг уур

***Цаг уурын олон жилийн дундаж*** -1981-2010 оны дундаж *үзүүлэлтээс тооцож гаргаж байна.*

***Агаарын температур*** *- дулааны төлөв байдлыг илэрхийлэх хэмжигдэхүүн.*

***Хур тунадас -*** *тухайн хугацаанд газрын гадаргын тодорхой нэг хэсэгт орсон хур тунадасны нийт хэмжээ нь шингэн болон хатуу хэлбэрээр орсон эсвэл хэт хөрөлтөөс шалтгаалан газрын гадарга, ургамал, бусад биет дээр агаараас буусан усны хэмжээ.*

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

**Хот орчмын агаарын чанар** – дараах үзүүлэлтүүдээр илэрхийлнэ:

- Агаарын чанарын ажиглалтаар хотын агаарт жилийн хугацаанд нийт хэмжлийн хэдэн хувьд нь агаарын чанарын стандартад заасан жилийн дундаж хүлцэх хэм хэмжээнээс давсан тохиолдлын тоог хувиар
- Агаар дахь бохирдуулагч бодисуудын агууламж абсолют утга, хамгийн их агууламж

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

## СУМДЫН АГААРЫН ДУНДАЖ ТЕМПЕРАТУР, °С

| Сум | Станц | 2010 | 2011 | 2012 | 2013 |
|---|---|---|---|---|---|
| Есөнбулаг | Алтай | -0.9 | -1.4 | -1.5 | 0.4 |
| Алтай | Аж богд | 5.4 | 5.9 | 5.6 | 6.9 |
| Баян-Уул | Баян-Уул | 0.9 | 0.0 | 0.1 | 2.5 |
| Бигэр | Бигэр | 3.9 | 3.1 | 3.6 | 5.1 |
| Бугат | Бугат | 0.4 | 0.1 | 0.3 | 1.6 |
| Гуулин | Гуулин | -1.0 | -2.0 | -2.1 | -0.5 |
| Дарви | Дарви | 0.1 | -0.4 | -0.6 | 1.0 |
| Дэлгэр | Дэлгэр | -0.8 | -2.0 | -2.4 | -0.8 |
| Жаргалан | Жаргалан | 1.0 | -0.5 | -0.2 | - |
| Тайшир | Тайшир | -0.2 | -1.2 | -1.6 | 0.3 |
| Тонхил | Тонхил | -0.2 | -0.8 | -0.6 | 1.0 |
| Төгрөг | Төгрөг | 1.5 | 1.4 | 0.7 | 3.3 |
| Халиун | Халиун | 1.2 | 1.7 | 0.9 | 4.4 |
| Хөхморьт | Хөхморьт | 0.8 | -0.3 | 0.0 | 2.1 |
| Цогт | Тоорой | 6.0 | 3.8 | 5.1 | 7.1 |
| Цогт | Цогт | -1.8 | -1.5 | -2.8 | -0.8 |
| Цээл | Цээл | -1.0 | -0.8 | -0.8 | 0.6 |
| Чандмань | Чандмань | -1.6 | -1.3 | -2.8 | -0.7 |
| Шарга | Шарга | 5.0 | 2.4 | 3.4 | 5.8 |
| Эрдэнэ | Эрдэнэ | -1.5 | -1.6 | -1.5 | 0.2 |

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

## ТУНАДАСНЫ НИЙЛБЭР, ХУР ТУНАДАСТАЙ ӨДРИЙН ТОО

| Сумын нэр | Хур тунадасны нийлбэр /мм/ | | | | Хур тунадастай өдрийн тоо | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2010 | 2011 | 2012 | 2013 |
| Есөнбулаг | 215.3 | 206.7 | 173.4 | 183.5 | 96 | 91 | 91 | 97 |
| Алтай | 64.6 | 37.7 | 56.9 | 30.0 | 30 | 24 | 25 | 31 |
| Баян-Уул | 191.6 | 172.3 | 149.6 | 145.8 | 76 | 71 | 80 | 74 |
| Бигэр | 40.0 | 75.4 | 44.0 | 21.1 | 24 | 25 | 19 | 24 |
| Бугат | 83.8 | 102.0 | 39.5 | 56.6 | 62 | 52 | 54 | 46 |
| Гуулин | 139.6 | 135.1 | 109.3 | 127.9 | 32 | 34 | 27 | 31 |
| Дарви | 73.5 | 83.3 | 53.8 | 59.4 | 51 | 60 | 58 | 73 |
| Дэлгэр | 108.4 | 106.8 | 121.0 | 87.4 | 40 | 37 | 38 | 34 |
| Жаргалан | 106.4 | 107.4 | 82.6 | - | 64 | 57 | 38 | - |
| Тайшир | 127.2 | 146.9 | 102.2 | 101.5 | 54 | 54 | 45 | 64 |
| Тонхил | 103.3 | 82.9 | 97.2 | 125.7 | 61 | 66 | 62 | 61 |
| Төгрөг | 217.5 | 201.4 | 192.7 | 163.3 | 69 | 58 | 54 | 48 |
| Халиун | 139.5 | 96.8 | 113.4 | 26.3 | 77 | 51 | 34 | 41 |
| Хөхморьт | 95.2 | 59.2 | 104.6 | 113.4 | 56 | 49 | 56 | 53 |
| Цогт (Тоорой) | 61.6 | 97.2 | 81.2 | 40.4 | 21 | 33 | 20 | 26 |
| Цогт | 133.6 | 142.0 | 202.4 | 109.1 | 48 | 61 | 46 | 52 |
| Цээл | 125.0 | 140.8 | 107.5 | 96.9 | 62 | 60 | 53 | 49 |
| Чандмань | 69.6 | 125.2 | 209.1 | 31.6 | 69 | 60 | 64 | 41 |
| Шарга | 68.4 | 61.8 | 38.9 | 47.4 | 26 | 49 | 26 | 25 |
| Эрдэнэ | 63.2 | 165.3 | 151.4 | 74.8 | 36 | 52 | 32 | 28 |

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

## 10. Газрын нэгдмэл сан

***Монгол Улсын Газрын тухай хуулийн дагуу газрын нэгдмэл санг дараах байдлаар ангилдаг.***



## 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

***Хөдөө аж ахуйн газар*** *- Бэлчээр, хадлан, тариалан, атаршсан газар, хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулсан бусад газар хамаарна.*

***Хот, тосгон, бусад суурины газар*** *- Хот, тосгон, бусад суурины барилга, байгууламж, үйлдвэр, уурхайн дэвсгэр болон нийтийн эдэлбэрийн газар, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад байгаа газар хамаарна.*

***Нийтийн эдэлбэрийн газар*** *- Хот, тосгон, бусад суурины гудамж, талбай, зам, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн бус амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэг, оршуулгын газар, хог хаягдлын цэг, цэвэршүүлэх талбай зэрэг газар хамаарна.*

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

***Зам, шугам, сүлжээний газар** -Зам, шугам сүлжээний газарт цахилгаан, дулаан, ус хангамж, ариутгах татуурга, зам тээвэр, холбоо, мэдээллийн зориулалтаар хот, тосгон, бусад суурины гадна олгогдсон газар хамаарна.*

***Ойн сан бүхий газар** -Ой мод, загтай газар, модыг нь огтолсон талбай, ойн цоорхой, зурвас, ойг өсгөн үржүүлэхэд зориулсан, ой тэлэн ургах боломжийг хангахуйц газар хамаарна.*

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

***Аймаг орон нутгийн түвшинд***

- ***Нэг хүнд ногдох эдэлбэр газар***

- ***Нэг хүнд ногдох ойн нөөц***

- ***Нэг хүнд ногдох тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг тооцож гаргана.***

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Говь-Алтай аймгийн нийт газар нутгийн хэмжээ 14144.8 мян.га буюу Монгол Улсын газар нутгийн 9.0 хувийг эзэлж, газар нутгийн хэмжээгээрээ улсад 2-р байранд жагсаж байна.

2013 онд 2010 оныхоос хөдөө аж ахуйн газар 8.5 мян.га-гаар хорогдож, хот, тосгон, бусад суурины газар 0.3 мян.га, тусгай хэрэгцээний газар 8.1 мян.га-аар нэмэгджээ.

## АЙМГИЙН ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН АНГИЛАЛ

| Газрын нэгдмэл сангийн ангилал | Мянган га | Дунд эзлэх хувь |
|---|---|---|
| Нутаг дэвсгэр | 14144.8 | 100.0 |
| Үүнээс ХАА- газар | 8813.4 | 62.3 |
| үүнээс бэлчээр | 8801.9 | 62.2 |
| хадлан | 2.6 | 0.0 |
| тариалан | 4.9 | 0.0 |
| хот, тосгон, бусад суурины газар | 18.4 | 0.1 |
| зам, шугам сүлжээний газар | 7.6 | 0.1 |
| ойн сангийн газар | 1221.3 | 8.6 |
| усны сангийн газар | 14.3 | 0.1 |
| улсын тусгай хэрэгцээний газар | 4069.8 | 28.8 |

## 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

**Орон нутгийн түвшинд бодлого боловсруулах, төлөвлөх, анализ, дүн шинжилгээ хийхэд шаардлагатай мэдээллийн эх үүсвэр:**

- www.1212.mn
- Статистикийн эмхэтгэл
- Сар бүрийн танилцуулга
- Статистикийн тооллого, судалгааны хэвлэмэл тайлан
- Бусад статистикийн хэвлэмэл бүтээгдэхүүн

# 2. СТАТИСТИКИЙН ТОВЧООНД ТУСГАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

**Анхаарах асуудал:**

- Сум, багийн түвшинд бололцоот мэдээллийн эх үүсвэрийг бий болгох
- Мэдээллийн динамик эгнээг урагшлуулах
- Урт хугацааг хамарсан мэдээллийн санг бүрдүүлэх

# 3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ИНДЕКС, ХОЛБОГДОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## 3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ИНДЕКС, ХОЛБОГДОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ҮСХорооны даргын 2014 оны 9-р сарын 11-ний өдрийн А/101 тоот тушаалаар батлагдсан" Орон нутгийн эдийн засгийн статистикийн үзүүлэлтүүд, тооцон хэрэгжүүлэх төлөвлөгөөнд:

1. Тухайн засаг захиргааны түвшинд гаргаж байгаа үзүүлэлтүүдийг тодорхойлох,
2. Үзүүлэлтийг тухайн засаг, захиргааны түвшинд шинээр тооцож, гаргах.
3. ҮСХ-ны зөвлөмжөөр сум /дүүрэг, баг/ хорооны түвшинд тухайн засаг захиргааны нэгж гаргах боломжтой.

## 3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ИНДЕКС, ХОЛБОГДОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

# Тухайн засаг захиргааны түвшинд шинээр гаргах үзүүлэлтүүд

| д/д | Орон нутгийн үзүүлэлтүүд | Давтамж | Засаг захиргааны түвшин |
|---|---|---|---|
| 1 | *2* | *3* | *4* |
| **I. ДНБ** | | | |
| 1 | *ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, харьяатын зарчмаар* | *жилд* | *Сум, дүүргээр* |
| 2 | *ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, нутаг дэвсгэрийн зарчмаар* | *жилд* | *Аймаг, нийслэлээр* |
| 3 | *Нэг хүнд ногдох ДНБ,* | *жилд* | *Сум, дүүргээр* |
| 4 | *ДНБ-д хувийн хэвшлийг эзлэх хувь* | *жилд* | *Аймаг, нийслэлээр* |
| **II. Үнэ** | | | |
| 5 | *Гол нэрийн зарим барааны жилийн дундаж үнэ* | *жилд* | *Сум, дүүргээр* |

## 3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ИНДЕКС, ХОЛБОГДОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| **III. Хөрөнгө оруулалт** | | | |
| 6 | *Дотоодын ХО-т, улс орон нутгийн санхүүжил-тийн эх үүсвэрээр* | *жилд* | *Аймаг, нийслэлээр* |
| **IV.Хуримтлал** | | | |
| 7 | *Хуримтлал, хөрөнгийн ангилалаар* | *жилд* | *Аймаг, нийслэлээр* |
| **V. Мөнгө, зээл** | | | |
| 8 | *Нийт хадгаламж, оны эцэст, хугацаатай болон хугацаагүй, төгрөгөөр,* | *жилд* | *Аймаг, нийслэл, сум, дүүрэг* |
| 9 | *Зээлийн өрийн үлдэгдэл, оны эцэст,* | *жилд* | *Сум, дүүрэг* |
| **VI. Даатгал, ББСБ, ХЗХоршоод** | | | |
| 10 | *Малын индексжүүлсэн даатгалын хураамжийн орлого* | *жилд* | *Аймаг, нийслэл, сум, дүүрэг* |

# 3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ИНДЕКС, ХОЛБОГДОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| **IX. Малчин өрх** | | | |
| 11 | *Хоршоонд хамрагдсан малчин өрхийн тоо* | *жилд* | *Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг хороо* |
| **XI. ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэл** | | | |
| 12 | *Сүү, цагаан идээний үйлдвэрлэл* | *жилд* | *сум, дүүрэг* |
| 13 | *Ноос ноолуурын үйлдвэрлэл* | *жилд* | *сум, дүүрэг* |
| 14 | *Арьс ширний бэлтгэл* | *жилд* | *сум, дүүрэг* |
| **XII. Тариалсан талбай, хураасан ургац** | | | |
| 15 | *Тариалсан талбай, төрлөөр* | *Улирал, жилд* | *Сум, дүүрэг, баг, хороо* |
| 16 | *ААНБ-ын тариалсан талбай, төрлөөр* | *Улирал, жилд* | *Сум, дүүрэг, баг, хороо* |

## 3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ИНДЕКС, ХОЛБОГДОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| 17 | *Хураасан талбай төрлөөр* | *Улирал, жилд* | *Сум, дүүрэг, баг, хороо* |
| 18 | *Хураасан ургац, өвс, хадлан төрлөөр* | *Улирал, жилд* | *Сум, дүүрэг, баг, хороо* |
| 19 | *ААНБ-ын хураасан ургац, өвс, хадлан төрлөөр* | *жилд* | *Сум, дүүрэг, баг, хороо* |
| 20 | *Өрхийн хураасан ургац, өвс, хадлан төрлөөр* | *жилд* | *Сум, дүүрэг, баг, хороо* |
| 21 | *Жимс, жимсгэнийн тариалсан талбай, төрлөөр* | *жилд* | *Сум, дүүрэг, баг, хороо* |
| 22 | *Жимс, жимсгэнийн нийт бут, модны тоо, төрлөөр* | *жилд* | *Сум, дүүрэг, баг, хороо* |
| 23 | *Жимс, жимсгэнийн хураасан ургац, төрлөөр* | *жилд* | *Сум, дүүрэг, баг, хороо* |
| 24 | *Бэлчээр, хадлангийн талбайн хэмжээ* | *жилд* | *Сум, дүүрэг, баг, хороо* |

## 3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ИНДЕКС, ХОЛБОГДОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| 25 | *Тариалангийн талбайн хэмжээ* | *жилд* | *Сум, дүүрэг* |
| **XIII. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл** | | | |
| 26 | *Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээг-дэхүүний үйлдвэрлэл, нэр төрлөөр* | *жилд* | *Аймаг, нийслэл* |
| **XV. Авто тээвэр** | | | |
| 27 | *Техникийн үзлэгт хамрагдсан автомашины тоо, төрлөөр* | *жилд* | *Сум, дүүрэг,*<br><br>*Баг, хороо* |
| **XVI. Харилцаа, холбоо** | | | |
| 28 | *Суурин утасны цэгийн тоо* | *Улирал, жилд* | *Сум, дүүрэг,*<br>*Баг, хороо* |
| 29 | *Үүрэн утас хэрэглэгчдийн тоо* | *жилд* | *Сум, дүүрэг,*<br>*Баг, хороо* |
| 30 | *Кабелийн телевиз хэрэглэгчдийн тоо* | *жилд* | *Сум, дүүрэг,*<br>*Баг, хороо* |

# 3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ИНДЕКС, ХОЛБОГДОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| **XVIII. Бизнес регистр** | | | |
| 31 | *Нийт байгууллагын тоо* | *жилд* | *Сум, дүүрэг* |
| **XXII. Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа** | | | |
| 32 | *Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ* | *жилд* | *Аймаг, нийслэл* |



# АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА

## www.1212.mn

Цахим шуудан: govi-altai@nso.mn
Портал сайт: **http://govi-altai.nso.mn/**